



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



BEST

Business Excellence for Sustainability and Transparency

**ХӨГЖЛИЙН
ШИЙДЭЛ**
УНШВАР ҮР ДҮНДЭЙН ШИДЭЛ



Баян хийц ББН	6
Даргиат найман шарга ХХК	8
Фореко ХХК	10
Мөнх Халдун Тэнгэр ХХК ХХК	12
ТИНЦ ХХК	14
Ц брэнд	16
Моод коллекшн ХХК	18
Ширмэл ширдэг брэнд	20
Хөх урлан ХХК	22
Цайдам трейд ХХК	24
Их Чандманьт Очир ХХК	26
Их-Өсөлт ХХК	28
Мөнгөнцой ХХК	30
Жасүда ХХК	32
Номгис ХХК	34
Тэргүүн Ти Жи групп ХХК	36
ЗУ ЗУ ХХК	38
Хайнаг Толгой Хоршоо	40
Дею Шүүдэр ХХК	42
Агора Арт Монголия ХХК	44
Маяара брэнд	46
Гүн Үйл ХХК	48
Сумака Гутлын Салон	50
Сүүн гэр ХХК	52
Индранил малц ХХК	54
Сэцэн фэйшн ХХК	56
Бүүвэй кашемир ХХК	58
Энхрий брэнд ХХК	60
Литлэ хэвин ХХК	62
Хүүгийн гутал ХХК	64
Түмэн түгээлт ХХК	66
Нандин Урлал брэнд	68
Нүүдэлчин сэрэхүй	70

МОНГОЛ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

ТАНИЛЦУУЛГА

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

Товч түүх

2008 оны 8 сарын 14 өдөр үүсгэн байгуулагдсанаасаа хойш хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийнхөө хүрээнд харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих олон талын үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна.

Алсын хараа

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч шинэлэг, үр дүнтэй, шилдэг байгууллага байна.

Эрхэм зорилго

Хөгжлийн Шийдэл нь Шинэлэг, Үр дүнтэй, Шилдэг шийдлээр:

- Өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулна.
- Өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгоно.
- Байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Үндсэн үйл ажиллагаа:

- БИЗНЕСИЙН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ;
- БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ;
- БИЗНЕСИЙН БҮЛЭГ, ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР;
- ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР;
- ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР;
- ТББ-ЫГ ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ;
- МЕНТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ;

BEST ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО: Жижиг Дунд Бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөхөд чиглэнэ.

BEST хөтөлбөр нь дараах таван зорилтыг ханган ажиллана:

ЗОРИЛТУУД

1. ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх;
2. ЖДБ-ийн засаглалыг сайжруулах;
3. ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагуудын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
4. Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх;
5. Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах боломжгүй ТББ, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох.

BEST хөтөлбөрийн үйл ажиллагаа:

- ЖДБ-ийн төлөвлөлт болон менежментийн сургалт, зөвлөгөө;
- ЖДБ-ийн сайн засаглалыг бий болгох, бэхжүүлэх сургалт, зөвлөгөө;
- Зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- ЖДБ-ийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрийн болон ТББ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны дотоод хяналтын системийг бэхжүүлэх, санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн сургалт, зөвлөгөө, хамтын ажиллагаа;

Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр нь 2020 оноос 2024 он хүртэл нийт таван жилийн хугацаатай хэрэгжинэ. Тус хөтөлбөр нь Улаанбаатар хот, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Ховд, Орхон, Сэлэнгэ, Завхан, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад хэрэгжиж байна.

ТЭРЭМ

*Дурсамжит мөгийг тань
бид бүтээлцэнэ*

Бидний эрхэлдэг бизнес бол “Тэрэм” брэндийн ойн хаягдлыг дахин ашигласан модон бэлэг дурсгал болон гэр бүлийн “Эвт” хөлөгт тоглоом юм. Анх эрүүл тоглоомоор гэр бүлээрээ тоглох хүслээр эхлүүлж байсан ажил маань 3 жилийн дараа Номин сүлжээ дэлгүүр, Шинэ нисэх буудал, Эко лайф Монголиа гэх мэт 10-д дэлгүүр болон 2 онлайн дэлгүүрээр байнга борлуулагдаж, Солонгос, Япон, АНУ, Франц зэрэг орнуудад худалдан авагчидтай болж улам өргөжсөөр байна. Одоогоор 3 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа бөгөөд цаашид өв уламжлал, түүх соёлоо таниулах, гэр бүлийн хөлөгт “Түүхэн” цуврал тоглоомуудаа үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Баян хийц ББН

☎ 8071-0988 | 9652-0988

бэлэг дурсгал 📷 teremgifts

✉ mongolgoo@yahoo.com

📍 www.teremgifts.com

🌐 Тэрэм-Монгол

1. Эвт тоглоом

5 хошуу мал, сарлаг нийт 6 амьтны зурагтай, үндэсний мал аж ахуйг таниулах зорилготой, даавуун ууттай, сэтгэхүй хөгжүүлэх гэр бүлийн тоглоомууд. Амандаа хийсэн ч аюулгүй. Бактерийн эсрэг амин тос дусааж гэр бүлээрээ эрүүл байж, дурсамж бүтээгээрэй.

2. Хөргөгчийн наалт, аяганы суурь

Уламжлалыг харуулсан зурагтай, шинэс модоор хийгдсэн, гэрт байхад модны тансаг үнэр үнэртэхээс гадна, стресс болон сэтгэл зүйн эрүүл мэндэд эергээр нөлөөлдөг.

3. Савангийн тавиур


V хэлбэртэй хийгдсэн учир ус тогтохгүй, саван байнга хуурай байлгахаас гадна цэвэрлэхэд эвтэйхэн.

4. Гэр хэлбэртэй түлхүүрийн өлгүүр

2 ш дэгээтэй, түлхүүр болон жижиг эд зүйлс өлгөж хэрэглэнэ. Уламжлалт гэрийн загвараар сийлж урласан. Ард нь байгаа наалтыг дуртай газраа нааж тогтооно.

5. Лааны суурь

Шинэс модоор хийгдсэн, цайны жижиг лаанд зориулсан бөгөөд цэвэр мод учраас дуртай үнэртэй эфирийн тосоо дусааж үнэртүүлэгч болгон ашиглах боломжтой.





**ЭЭЗГИЙНИЙ
АМТТАН**

Монгол амттанаар монголчуудыг гайлна

“Амсаж үзсэн хүн бүр л “Ямар гоё юм бэ? энэ юу вэ?” гэж уулга алдсаар худалдан авалт хийдэг байсан тул 2006 оноос эхлэлтэй зөвхөн цагаан сарын үеэр л явуулдаг байсан өрхийн жижиг бизнесээ 2019 оноос албан ёсны бүтээгдэхүүн болгон тогтмол үйлдвэрлэдэг болсон. 2020 оноос Номин, Имарт гэх мэт томоохон дэлгүүрүүдээр борлуулж эхэлсэн ба бүтээгдэхүүнээ илүү олон хэрэглэгчдэд хүргэж чадсан ба одоогоор нийт 45 цэгээр дамжуулан борлуулалт хийж байгаа. Цагь ээзгийний амттан нэрээр зах зээлд бүтээгдэхүүнээ таниулж, бүтээгдэхүүнд агуулагдах амин дэм, эрдэс бодисуудыг илүү олон хэрэглэгчдэд хүргэхээр ажиллаж байна.



ДАРГИАТ НАЙМАН ШАРГА ХХК

☎ 91145267, 99043627

✉ dargiattsagi@gmail.com

📍 ЦАГЬ ээзгийний амттан - eezgiinii amttan

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 14-р хороо, 16-9 тоот

Бүх насныхан хэрэглэхэд тохиромжтой,



идэхэд амттай, зөөлөн, өөг бүтээгдэхүүн



ОЮУНЫ ӨМЧӨӨР БАТАЛГААЖСАН ОРЦТОЙ, ЭРҮҮЛ МОНГОЛ АМТТАН
ХЭЭРИЙН САЛХИНД СЭВРЭЭЖ ХАТААСАН ЗАВХАН, ХӨВСГӨЛ НУТГИЙН ЭЭЗГИЙГ
АРХАНГАЙ, ХӨВСГӨЛ АЙМГИЙН САРЛАГИЙН ӨРӨМ, ОВЪЁОС, ЧИХРЭЭР БАГСАРЧ ХИЙСЭН
ЦОРЫН ГАНЦ, ШИНЭ МОНГОЛ АМТТАН.

- Эээгий, Зөөхий, Овьёос + Элсэн чихэр
- Эээгий, Зөөхий, Овьёос + Бор элсэн чихэр
- Эээгий, Зөөхий, Овьёос + Зөгийн балтай гэсэн төрлүүдтэй
- 200гр, 400гр, 800гр-ын савлагаатай



ЧАНАР БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Монгол улсдаа зөгийн аж ахуй, газар тариалангаараа тэргүүлдэг Сэлэнгэ аймгийн Шаамар суманд манай аж ахуй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2013 оноос эхлэн хэрэглэгчдэд 100% цэвэр зөгийн балыг хүргэх зорилго тээн "Тансаг" нэрийн зөгийн балыг зөгийн үүрнээс хурааж, ямар нэгэн баяжуулалт хийлгүй хэрэгцээнд нийцүүлэн савлаж хэрэглэгчдийн гарт хүргэж ирсэн билээ. 2017 оноос эхлэн олон төрлийн савлагаатай тансаг зэрэглэлийн "NECTA" брэндээ хэрэглэгчдэд хүргэж эхэлсэн ба Худалдаа аж үйлдвэрийн танхимаас жил бүр зохион байгуулдаг "SME's 2017" жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн олон улсын үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож Дэлхийд өрсөлдөх Монгол брэнд хэмээх нэр хүндтэй шагналын эзэн болсон нь маш их урам зориг өгсөн билээ.



ФОРЕКО ХХК

☎ (+976) 91918033, (+976) 89852858 ✉ foreco.mn@gmail.com 📱 [Necta honey/ Нэкта зөгийн бал](https://www.facebook.com/Necta.honey/)

Олон төрлийн
эмийн ургамлын
амтат шүүсний
нэгдэл **Necta зөгийн
балыг** танд хүргэж
байна



Өглөөний цай уухаас 15-20 минутын
өмнө 37 градусын бүлээн 250
мл усанд 1 халбага буюу 10 гр
зөгийн бал найруулан уухад хоол
боловсруулах эрхтний үрэвслийг
анагаахын зэрэгцээ хэвийн үйл
ажиллагааг хангахад чухал ач
холбогдол үзүүлдэг. Өдөрт 20-30 гр
зөгийн бал хэрэглэх нь тохиромжтой.
Зөгийн балыг анх хурааж авах үед
ургамлаас хамааран цэнхэр цагаан,
шар, улбар шаргал, шар ногоон, бор
зэрэг өнгөтэй шингэн хэлбэртэй
байх ба температур багасах үед
ширхэгтэй, цагаан өнгөтэй болон
царцдаг. Хэрэв зөгийн бал талсжин
цагаан өнгөтэй болж царцсан бол
37-40 градусын бүлээн усанд шилтэй
нь хэсэг хугацаанд суулгах хэрэгтэй.
Ингэснээр бал хайлж шингэн
хэлбэртэй болох болно.



Necta зөгийн бал дараах гурван төрлөөс бүрдэнэ:

• **Байгалийн олон цэцэгсийн бал:**

Олон төрлийн балт ургамлын
амтат шүүсний нэгдэл учраас эрүүл
мэндийн ач холбогдол өндөртэй
зөгийн бал.

• **Рапсны бал:**

Нэг төрлийн ургамлын элдэв янзын
үнэр, амтгүй маш зөөлөн бал учраас
ходоод, гэдэсний үйл ажиллагаанд
сайн нөлөө үзүүлнэ.

• **Гурвалжин будааны бал:**

Уураг, төмрийн агууламж өндөртэй
эрүүл мэндийн ач холбогдол
өндөртэй зөгийн бал.

Уламжлалыг технологитой хослуулж тэргүүн чанарыг бүтээв

Мөнх Халдун Тэнгэр ХХК нь 2019 онд хүний эрүүл мэндийг дэмжих, зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр байгуулагдсан. Компани анх байгуулагдсан цагаасаа хэрэглэгчдэд хамгийн цэвэр, чанарын шаардлага хангасан барагшун болон барагшунтай бүтээгдэхүүнийг хүргэхээр зорьсон. 2019 ба 2020 оны заагт буюу Ковидын үеийн амаргүй цаг хугацаатай давхцан манай байгууллагын үйл ажиллагаа эхэлсэн нь бидний хувьд хүндхэн сорилт болсон. Тэгсэн хэдий ч бид өөрсдийн бүхий л нөөц бололцоог дайчлан хүнд үеийг давж гарахаар ажиллаж байна. Учир нь Ковидын нөлөө одоо хүртэл үргэлжилсэн хэвээр байгаа ба хэрэглэгчид, байгууллагууд цаг үеийн хүндрэлээс хараахан гарч амжаагүй байна хэмээн харж байна.

Компани маань анх 2 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэж байсан бол одоо 4 төрлийн бүтээгдэхүүнийг 7 төрлийн савлагаатайгаар зах зээлд нийлүүлдэг болсон. Компани байгуулаад үйлдвэрлэл, борлуулалт, хүргэлт, маркетинг гээд бүх зүйлд ганцаараа байсан бол одоо нийт 4 болж бага багаар өргөжиж байна.

Энэ жил үйлдвэрийн байрандаа засвар хийж ажлын байрныхаа орчин нөхцөл, ажилчдын тав тухтайорчиндажиллах нөхцлийг сайжруулахаар хичээж байна. Мөн борлуулалтаа зөвхөн

Улаанбаатар хотод хийдэг байсан бол одоо нийслэлээс гадна 10 гаруй аймгийн төвүүдэд өөрийн бүтээгдэхүүнийг борлуулж байна.

МӨНХ ХАЛДУН ТЭНГЭР ХХК

☎ 88125575 | 88947711 📍 Стандарт Барагшун 📷 Стандарт барагшун 🌐 www.baragshun.mn



“ЗӨГИЙН БАЛТАЙ ШИНГЭН БАРАГШУН

30 ширхэгтэй- Байгалийн зөгийн балаар баяжуулсан учир барагшуны гашуун амтыг зөөлрүүлж уухад тааламжтай болгож өгсөн ба 1 хүний 15 хоногийн хэрэглээ болно. Савлагааны хувьд 1 удаад задлаад шууд уух зориулалттай хэрэглэхэд хялбар тохиромжтой. Мөн бүх насны хүмүүс хэрэглэх боломжтой эрүүл мэндийг дэмжих үндэсний бүтээгдэхүүн юм.

Зөгийн балтай шингэн барагшун 10 ширхэгтэй

Дархлаа дэмжих байдлаар хэрэглэж болох ба үүнээс гадна аливаа баяр ёслол, байгууллагын хүлээн авалт зэрэгт гарын бэлгэнд сонгоход нэн тохиромжтой байдлаар савлагдсан байдаг.

БАЯРЫН БЭЛГИЙН БАГЦ

Багцад дараах 3 бүтээгдэхүүн багтана.

- Зөгийн балтай шингэн барагшун 5 ширхэгтэй
- 1 "Авшиг" Ванны дүрлэг
- 1 /хайрцагтаа 16 ш-ээр савласан/
- "Анарваань" барагшунтай цай /30 ширхэгтэй/
- 1 Анарваань

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ

30 ширхгээр савлагдсан

Өдөр тутмын цайны хэрэглээндээ хэрэглэж болох барагшуны цэвэр охиор баяжуулсан жасмин цайны ханд юм. Буцалсан халуун усанд хандалж эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор ууж болно.

АВШИГ- ВАННЫ ДҮРЛЭГ БҮТЭЭГДЭХҮҮН

Хайрцагтаа 16 ширхгээр савлагдсан

Монголчуудын ахуй соёлд бага насны хүүхдийг бор цай, ясны шөлөнд оруулах зэрэг уламжлалт аргууд байдаг. Үүний гол зорилго нь хүүхэд багачуудын дархлааг дэмжих, бат бөх нойрсох зэрэгт оршдог. Тэгвэл тухайн бүтээгдэхүүн нь арьсаар дамжуулан хүний биед эрдэс бодис, амин дэмийг шингээж өгөх зориулалттай юм. Зөвхөн хүүхэд гэлтгүй том хүн ч хэрэглэх боломжтой. Мөн арьсны аливаа харшил, эмгэгтэй хүмүүс хэрэглэхэд нэн тохиромжтой эмчилгээний зорилгоор хэрэглэж болох бүтээгдэхүүн юм.

Барагшуны өтгөрүүлсэн ханд 100мл

Барагшуны өтгөрүүлсэн ханд нь ямар нэгэн нэмэлт хольцгүй цэвэр охь хэлбэрээрээ савлагддаг. Тус бүтээгдэхүүн нь 1 хүний 2 сарын хэрэглээ болж өгдгөөрөө эдийн засгийн хэмнэлттэй гэж болно. Мөн зөгийн бал зэрэг чихэрлэг зүйлсээс зайлсхийдэг хүмүүс, чихрийн шижин өвчтэй хүмүүст илүү тохиромжтой үр дүн сайн байдаг.



2017 оны дундаас одоог хүртэл хүнсний ногооны шүүсээр
“НОГООДОЙ” нэрийн доор 5 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Үүсгэн байгуулагч Б.Туяа миний бие БНСУ-д 5 жил ажиллаж байхдаа 3 жил нь Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газар ажиллан тэнд сурсан технологи, ноу хаугаараа эх орондоо ирэн ажлын байр бий болгон үйлдвэрлэлээ эхэлсэн.

Сонгино хушны шилмүүсний ханд, Хүрэн манжингийн ханд, Хар саримсны ханд, Улаан чавга цагаан гааны ханд, Байцай Лууван Цэцэгт байцайны ханд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг. Чанар эрүүл ахуйн стандартыг хангасан манай бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сайнаар нөлөөлөн урьдчилан сэргийлэх, химийн найрлагагүй зэрэг олон давуу талуудаараа худалдан авагч хэрэглэгчдэдээ үнэлэгдэж байна. Манай компани гол түүхий эд болох хүнсний ногоогоо “Гацуурт Хүнс”, “Сэлэнгэ Органик” хоршоо нь Монголын хамгийн анхны органик тариалалттай, “Цэвэр Хөрсний Шим” хоршоо нь газар тариалангийн зохистой дадал буюу GAP нэвтрүүлсэн тариалан эрхлэгчээс, сав баглаа боодлоо дотоодоос Финпак, ЭкоПак, ОБ пластикаас авдаг. Мөн хаягдал болох ногооны эд, хальсыг компост бордоо болгон тариаланчаа органик бордоогоор ханган чанартай түүхий эдээр, гарал үүсэл тодорхой, аюулгүй хүнсээр хэрэглэгчийг хангах зорилттой байгаль дэлхийдээ ээлтэй тойргон эдийн засгийн хэлбэрээр үйлдвэрлэл явуулдаг.

Тогтвортой хөгжлийн 2, 3, 5, 8, 12 13 зорилтуудыг ханган ажиллаж байна.

ТИНЦ ХХК

☎ 96003343, 88114720 ✉ nogoodoi34@gmail.com 🌐 Nogoodoi organic ногооны цэвэр шүүс

📍 Хан-Уул дүүрэг, 11-р хороо, “Оргил Рашаан Сувилал” ХХК байр

Бид Монголд ургуулж үйлдвэрлэснийг сонгодог



Сонгины ханд



"Улаан чавга&Цагаан гааны ханд



Холимог ногооны шүүс



Хүрэн манжингийн ханд



- 2020 онд “Арьс шир–ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарын 14-р үзэсгэлэн”-ийн онцлох бүтэгдэхүүнээр шалгарав.
- 2021 онд “Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн зохион байгуулагдсан “Цүнх үйлдвэрлэгч нарын улсын анхдугаар уралдаан”-д оролцож “Эрэгтэй цүнх”-ний төрөлд 3-р байранд оров.
- 2022 онд ХХААХҮЯ, МАШҮХ-с зохион байгуулсан “Цүнх үйлдвэрлэгчдийн мэргэжлийн ур чадвар шалгаруулах улсын анхдугаар уралдаан”-д оролцож ТУСГАЙ байр эзлэв.
- 2022 онд “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-
- 2022”олон улсын үзэсгэлэн яармагт амжилттай оролцож “Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн”-ээр шалгарав.



СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭЖ -
ЭХ ОРОНДОО ҮЙЛДВЭРЛЭВ


Ц-БРЭНД НЬ 2019 ОНООС ЭХЛЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИДЭВХЖҮҮЛЭН ӨӨРИЙН НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ҮЙЛДВЭРЛЭЖ ЭХЭЛСЭН. ЦЭВЭР ҮХРИЙН АРЬСАН ЦҮНХ, ЖИЖИГ ЭДЛЭЛИЙГ ЧАНАРЫН ӨНДӨР ТҮВШИНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭН ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛД БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ТАНИУЛАН НИЙЛҮҮЛЭХЭЭР ЭРЧИМТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛД СҮҮЛИЙН 5-35 ЖИЛИЙН ТУРШ АЖИЛЛАЖ БАЙГАА, УРТ ХУГАЦААНЫ ДАДЛАГА ТУРШЛАГАТАЙ.

Ц-БРЭНД

☎ 976-8856-5929, 9595-5929 🌐 TS leather brand 🌐 www.tsleatherbrand.mn

📍 Салбар #1: УИД-ын чанх хойно 9-байр

📍 Салбар #2: Вокзал - Монголд үйлдвэрлэв төв №17 павилон



TS LEATHER
BRAND

“Монголд төдийгүй олон улсад боловсруулсан сайн чанарын үхэр, ямаа, тугалын арьсаар бүх төрлийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Захиалагч, хэрэглэгч, байгууллага, хамт олны лого, эмблем, дардас бүхий бүх төрлийн цэвэр арьсан бүтээгдэхүүнийг захиалгын дагуу цор ганц загвараар үйлдвэрлэдгээрээ онцлогтой. Жижиг эдлэл Картны гэр,эмэгтэй түрийвч, эрэгтэй түрийвч, түлхүүрийн оосор, үзэг балны сав, косметикийн сав, чипний гэр, үнэмлэхний гэр

Эмэгтэй цүнх

Орчин үеийн чиг хандлага бүхий гоёлын цүнх, оффис хэрэглээний цүнх, чөлөөт загварын жижиг цүнх, үүргэвч,


Эрэгтэй цүнх

Оффис хэрэглээний портфель,чөлөөт загварын жижиг цүнх,өдөр тутмын хэрэглээний гар цүнх,спорт загварын урзолк”



*“Ур хийц нь манайх,
сүлд хийморь нь таных”*

Манай үйлдвэр нь 2001 оноос 4 улирлын малгай үйлдвэрлэл, малгайны захиалга чиглэлээр үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд 2014 оноос "Моод коллекшн" ХХК болон өргөжсөн билээ. Манай компани гадаад болон дотоодын үзэсгэлэн хуалдаанд амжилттай оролцдог ба Улаанбаатар болон хөдөө орон нутагт 30 гаруй салбар дэлгүүрүүд мөн 2 нэрийн дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа эрхэлж байна. Улирлын онцлог болон загварын чиг хандлагаас хамааруулан бүх насны хүмүүст зориулсан, хөнгөн болоод дулаан шинж чанаруудаараа малгайнууд маань давуу талтай. Мөн захиалгаар цор ганц загвар гаргах бүрэн боломжтой.



МООД КОЛЛЕКШН ХХК

☎ 99176255 | 96016255 ✉ chimegbatb@yahoo.com ✉ moodcollectionhats@gmail.com 📘 Моод малгай

📷 mood_collection_malgai 🌐 <https://moodmalgai.zochil.shop/about>

📍 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, My Town хотхон, 112 байр, 101 тоот





Ширмэл ширдэг

Уламжлалт ширдэгээ ширэх аргаа сэргээх, хадгалах, хойч үедээ өвлүүлэх зорилготой

"Монголчууд бид олон зууны тэртээгээс нүүдлийн мал аж ахуй эрхлэн малын шимийг бүрэн ашиглаж ирсэн ард түмэн билээ. Үүний нэг жишээ нь эрт дээр үеэс ноосоор эсгий хийж, утас ээрч хатгаж, нэхэж, ширж төрөл бүрийн эсгий бүтээгдэхүүн урлан ахуй амьдралдаа өргөн хэрэглэж ирсэн явдал юм. Хонины ноосонд байдаг хөндий гуурс маягийн шинж чанар нь ноосыг дулаахан, тусгаарлах онцгой шинж чанартай болгож тухайн бичил уур амьсгалыг илүү тогтвортой байлгадаг. Мөн агаарын чийгшил их байх үед ноос өөрийн хувийн жингийн 40% хүртэлх чийгийг өөртөө шингээж, дулаан болгон ялгаруулдаг.

Бид эх орныхоо түүхий эдийг ашиглан эсгийгээр хүн ба байгаль орчинд ээлтэй удаан эдэлгээтэй, хөнгөн, дулаахан экологийн цэвэр бүтээгдэхүүн болох ширмэл ширдгийг хийдэг. Эсгий ширдгийг гараар удаан хугацаанд тэвчээртэй сууж урладаг учир энэ ажлыг сонирхон хийх хүний тоо, аж ахуй нэгж маш цөөн байгаа тул энэ орон зайг нөхөж, уламжлалт ширдэгээ ширэх аргаа сэргээх, цаашид хадгалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилготойгоор бид ажиллаж байна.

ШИРМЭЛ ШИРДЭГ БРЭНД

☎ 88696911, 99193136 ✉ mahaona1000@gmail.com 📘 Ширмэл Ширдэг

📍 Улаанбаатар Хот, Баянгол Дүүрэг, 18-р хороо 42-113



1кг хуурай ноосноос 960кдж энерги ялгардаг байна.



1999 оноос арьсан хүүхэлдэй болон арьсан цүнх, арьсан хантааз өрхийн хэмжээнд үйлдвэрлэж эхэлсэн. 2011 оноос Хөх урлан ХХК-г байгуулж албанбизнесболсон. Одоо 8 ажилтантай, өөрийн нэрийн дэлгүүртэй үйл ажиллагаагаа явуулж байна. Нэрийн дэлгүүрээс гадна 20 гаруй дэлгүүр, хувь хүнд бараа бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. 2005 онд Япон улсад зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд оролцож арьсан урлалын чиглэлээр тэргүүн байр эзэлсэн. Улаанбаатар хот болон гадаад улсад зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцдог. Орчин үеийн загвар чиг хандлагыг бүтээгдэхүүндээ шингээн хэрэглэгчдийн хүсэл сонирхолд тулгуурлан байнга өөрчилж шинэчилж байдаг.

ХӨХ УРЛАН ХХК



☎ 99276897

✉ Khukhurlan@gmail.com

📘 [Khukh urlan llc](#)

📷 [khukh urlan](#)

📍 ЧД, 3-р хороо, 2-р 40 мянгат 16 байр 19 тоот





✿ Сэтгэл шингээж шиний эрхэмлэнэ





BURAMHAN
HAND CRAFTED CANDY



Манай компани 2007 онд байгуулагдсан бөгөөд 2016 оны хоёр дугаар хагасаас эхлэн гараар урласан хатуу чихрийг Монголын зах зээлд нийлүүлэх энэхүү төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Улмаар бүтээгдэхүүнийг 2017 оны 6-р сараас эхлэн одоог хүртэл нийт 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд Улаанбаатар хотын 300 орчим цэгээр нийлүүлж байна.

БУРАМХАН хатуу чихэр нь дахин давтагдашгүй хэлбэр дүрсийг урлаж, олон төрлийн байгалийн цэвэр жимсний охь агуулсан гайхалтай амттан юм.

ЦАЙДАМ ТРЕЙД ХХК

7012 9222

✉ buramhancandy@gmail.com

f Buramhan

🌐 <https://buramhan.com>

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Дэм төвийн 16 тоот



Бид ойн
баярууд,
төрсөн өдөр,
хурим найр гэх
мэт тэмдэглэлт
арга хэмжээнд
зориулан танай
байгууллагын
нэр, лого дүрсийг
таны хүссэн
амтаар дахин
давтагдашгүй, төгс
төгөлдөр урлана.





Бувэй брэнд - Цэс өвд өвлөгдөнө

БҮҮВЭЙ БРЭНД НЬ 2014 ОНД ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРААС АЛБАН ЁСНЫ
"БАРААНЫ ТЭМДЭГТ"-ЭЭ АВСНААР ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЭЛСЭН. ХАМГИЙН
АНХ ХҮҮХДИЙН НЭХМЭЛ МАЛГАЙ, БОЙТОГ ОЁЖ ИНТЕРНЕТЭЭР ХУДАЛДААЛЖ
ЭХЭЛСЭН. ХОНИНЫ НЭХИЙГЭЭР ГУДАС, НЭХИЙ ДЭВСГЭРХИЙЖ ЭХЭЛСЭН.

ИНГЭСНЭЭР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

НЭР ТӨРӨЛ НЭМЭГДЭЖ, ЗОРИЛТОД БҮЛГИЙН ХҮРЭЭ ТЭЛСЭН." "ҮХРИЙН
ШИР, ХОНИНЫ НЭХИЙ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮДТЭЙ ХАМТРАН
АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН. ИНГЭСНЭЭР ОЁДЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭ
МЭДЭГДЭХҮЙЦ НЭМЭГДСЭН."

ИХ ЧАНДМАНЬТ ОЧИР ХХК

☎ 88862144 ✉ badamrinchin@gmail.com 🌐 <https://www.facebook.com/buuveibrand> 🌐 <https://buuveibrand.mn/>

📍 Улаанбаатар хот, СХД, 32-р хороо, Бичигт 25-10 тоот





ARIGUN

*Аригун тансаг үнэртний дээд
Аз жаргалтай амьдралын гэгээ*

Манай компани 2017 оноос "Аригун" брэндийн анхилуун үнэртэй лаа болох хамгийн сайн чанарын шар буурцагны /Soy wax/ тосноос гаргаж авсан, шатах явцдаа бусад лаанаас 95% бага тортог гаргадаг, экологийн цэвэр бүтээгдэхүүнийг Монгол Улсдаа үйлдвэрлэн, худалдаалж байна. Бид "Органик-Эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй", "Баялагийг хэмнэх-дахин ашиглах" уриан дор өөрсдийн хийж буй бүхий л зүйлээрээ нийгэмд зөв хандлагыг бий болгож, зөв үлгэр дуурайлал болохыг зорьж явна.

ИХ ӨСӨЛТ ХХК

☎ 70126882, 99992420, 99166690 ✉ ikhusult@gmail.com 📘 arigun luxury brand 📷 [arigunluxurybrand](https://www.instagram.com/arigunluxurybrand)

🌐 <https://arigunbrand.com/> 📍 БГД-н 4-р хороо UB platinum 801 тоот

📍 **Нэрийн дэлгүүр:** Arigun boutique, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Шангри-Ла Моллын зүүн талд байрлалтай
Олимпик Галлериа 1-р давхарт





2012 ОНООС ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЭЛСЭН.
МОД, ХӨӨСӨНЦӨР, ТӨМӨР, МӨС ЗЭРГЭЭР БҮХ ТӨРЛИЙН
СИЙЛБЭР БҮТЭЭЛ СИЙЛДЭГ.

ДАХИН ДАВТАГДАШГҮЙ, ЧАНАР ОРЧИН
ҮЕИЙН ДИЗАЙН

МӨНГӨНЦОЙ ХХК

☎ 99049298 ✉ tserenbat321@yahoo.com 📘 Мөнгөнцой ХХК

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 10, 419 тоот



"ЖАСҮ брэнд нь бизнес төслөөрөө олон улсын болон дотоодын гарааны бизнесийн тэмцээн болон дэлхийн хэмжээний шоу нэвтрүүлэгт амжилттай оролцож өөрийн бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татаж чадсан.

Жишээлбэл:

- Бизнесийн хөрөнгө оруулалтын дэлхийн номер нэг шоу болох Шарк Танк нэвтрүүлгийн 1 дүгээр улиралд амжилттай оролцож өөрийн бизнестээ 24 200 000 хөрөнгө оруулалтыг татаж чадсан. 2017 он
- БЭЭТ төслийн инкубатор 2-т шалгарсан
- Дэлхийн 140 хотод зэрэг зохион байгуулсан Global women startup төслийн уралдаанд 3-р байр 2018он
- БГД залуучуудын гарааны бизнесийн төслийн уралдаан 1-р байр 2018 он
- Залуучуудын гарааны бизнесийг дэмжих төслийн уралдаанд 3-р байр 2017 он
- Эмэгтэйчүүдийн холбооны хүндэт тэмдэг 2022 он



ЖАСҮДА ХХК-ны "ЖасҮ" эсгий урлан нь 2017 оноос хойш Нүүдэлчин Монголчуудын эртний үйлдвэрлэлийн нэг болох эсгий хийх уламжлалт аргаар 100% монгол хонины ноосыг ашиглан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргахаас гадна, гар аргаар хийдэг олон нэр төрлийн эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байна.

Монгол хонины бүдүүн, бүдүүвтэр ноосоор хийсэн эсгий, эсгий эдлэл нь удаан эдэлгээтэй, экологийн цэвэр бүтээгдэхүүн учраас хүн ба байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд зориулагдах төдийгүй Монгол орны өв уламжлал, нүүдэлчин соёл, сэтгэлгээний илэрхийлэл юм. Мөн манай урлан нь хэрэглэгчдийн хүсэл сонирхлын дагуу ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг явуулдаг. Мөн манай урлан нь модон бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж зах зээлд борлуулалт хийхээр бэлтгэл ажилдаа ороод байна.

Бэлчээр нутгаас таны гарт

ЖАСҮДА ХХК

☎ 91006007 ✉ jasufelt@gmail.com 📘 [jasuproject](https://www.facebook.com/jasuproject)

📍 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 17 байр





Хуурай аргаар хийх ноосон бэлдэгч . Эсгий гутам, бойтог



Эсгий цунх . Эсгий тоглоом . Эсгий гоёл чимэглэл + ...



АРТИЗАН БЯСЛАГ
ARTISAN CHEESE



2021 оноос сүү
сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
худалдааны чиглэлийг үйл ажиллагаандаа
нэмж “АРТИЗАН БЯСЛАГ” үйлдвэрээ байгуулан бяслаг
үйлдвэрлэхээс гадна бяслаг урлаач Төмөрхуягийн ХУСТАЙ
ГОУДА бяслагийг зах зээлд борлуулах үйл ажиллагаа явуулж
байна. 2023 оноос эхлэн бяслаг урлаач Төмөрхуягийн Хустай ГОУДА
бяслаг үйлдвэрлэх know-how технологийг уламжлан авч “АРТИЗАН
БЯСЛАГ” үйлдвэртээ жилийн турш тасралтгүй үйлдвэрлэхээр
ажиллаж байна. “НОМГИС ХХК нь монголын бэлчээрийн мал аж
ахуйн гаралтай үнээний сүүгээр Европ бяслаг болох ХУСТАЙ ГОУДА,
Пекорино, Рикотта уураг, Пребиотик шар сүү үйлдвэрлэдэг.
Бидний борлуулж буй ХУСТАЙ ГОУДА нь Монголын анхны
брэнд бяслаг. Өнөөгийн зах зээлд манай бяслагууд
нь амт чанараараа хэрэглэгчдэд танигдсан
төдийгүй үнэ болон чанараараа дундаас
дээш ангилалд хамаарна.



НОМГИС ХХК

☎ 94107781

✉ enkhubat@yahoo.com

АРТИЗАН БЯСЛАГААР ДЭЛХИЙГ ДАЙЛЪЯА



“Үндэсний үйлдвэрлэгч Тэргүүн Ти Жи групп ХХК нь ноос, ноолууран оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн худалдаа, үйлчилгээний чиглэлээр 2 жил гаруй үйл ажиллагаа явуулж байна.

Тэргүүн Ти Жи групп ХХК нь 2019 онд байгуулагдаж, дэлхийн шилдэг шинэ техник технологийн бүтээгдэхүүнийг Snowfield компанитай хамтран Наран кашмер нэртэйгээр Монголын хэрэглэгчдэдээ санал болгон ажиллахаас гадна, өөрийн бүтээгдэхүүнээ оюуны өмчөөр баталгаажуулан Tergun брэндийг гарган 2021 онд 180 орчим сая төгрөгийн борлуулалт хийн амжилттай өсөн нэмэгдэж байгаа жижиг бизнес эрхлэгч компани билээ.



Манай хамтран ажиллагч компани нь олон улсын лаборатороор өөрийн үйлдвэрлэсэн ноос, ноолууран бүтээгдэхүүний чанарыг албан ёсоор баталгаажуулсан бөгөөд орчин үеийн хувцас загварын чиг хандлагатай хөл нийлүүлэн алхаж, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрхэм зорилгынхоо хүрээнд хэрэглэгчдийн хүсэл сонирхол, улирлын онцлогт тохирох эрэгтэй, эмэгтэй, хүүхэд болон ахуйн хэрэглээний чанартай бараа бүтээгдэхүүнийг хавар зун, намар өвөл, үндэсний хувцас, гоёлын даашинз болон хүүхдийн хувцасны коллекциудаар үйлдвэрлэн гаргаж байна. Түүхий эдийг сонгож авахдаа арга сайн байдаг учир сайн түүхий эд буюу утсыг сонгодог, суулт, өмсгөл сайтай, өрөлтүүд сайн, лангуун эвхэлт сайн, ТЭМ утасны чанар сайн, Товчны сонголт, цахилгааны сонголтыг сайн хийдэг, бөөсрөлт бага, илүү зөөлөн, борлуулалтын арга барил сайн, танил тал сайтай, хэрэглэгчийн дата тай болсон.

ТЭРГҮҮН ТИ ЖИ ГРУПП ХХК

☎ 99080139, 99078477 ✉ tergun.cashmere@gmail.com 🌐 facebook.com/tergun.mn 📷 [tergun_cashmere](https://instagram.com/tergun_cashmere)
🌐 www.tergun.mn 📍 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Их наяд плаза 345 тоот





“ ЗУ ЗУ ХХК нь 2016 оноос ноос, ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Сүлжмэлийн салбарын сайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Германы STOLL, Японы Shima Seiki брэндийн сүлжих машинууд дээр дотоодын ээрэх үйлдвэрүүдийн боловсруулсан ямааны ноолуур, сарлагийн хөөвөр болон хонь, тэмээний ноосон ээрмэл утсаар бүтээгдэхүүнээ хийдэг. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох оёдолгүй, бүтээгдэхүүнээр сүлждэг машин ашигладаг. ”



ЗУ ЗУ ХХК

☎ 99100911

✉ dulaanmgl@gmail.com; knittex@post.com

📘 Zuzuknitwearbrand

📷 Zuzuknitwearbrand

📍 Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Монгол Нэхмэл ХХК-ийн байр



0-3 хүртэлх насны нялх хүүхдийн оёдолгүй, давхар утасны зузаан ноолууран хувцас болон ноолуур, сарлаг, тэмээний ноосон утсаар нас,хүйс харгалзахгүй UNISEX загварын, чөлөөт размерын жижиг эдлэл - малгай, ороолт бээлий, оймс зэргийг үйлдвэрлэдэг. Shima seiki брэндийн оёдолгүй технологийн машинаар сүлжсэн 100% ноолууран хувцас нь нярайн зөөлөн биеийг холгохгүй, шууд өмсөхөд тохиромжтой бөгөөд натурал ширхэгт нь агаарын солилцоо сайн байж, хөлсийг гадагшлуулж байдаг. Мөн хүүхдийн хувцас нь сул чөлөөтэй, өргөсгөсөн загвартай байдаг нярайн хөдөлгөөнд саад болохгүй, өсөлтийг дэмжих, резинэн утас, полистерийн агууламжгүй байдаг нь харшил өгөхгүй, чийг татахгүй зэрэг эрүүл мэндийн олон давуу талтай. Эрүүл бойжиж хурдан торних эзэндээ багадах ч дурсамж болон зурагт мөнхөрч дүү нарт нь дамжина.



ДУЛААН ДУРСАМЖИНД ҮЛДЭНЭ






2012 оны 8-р сард 9-н гишүүнтэйгээр хүнтэй оёдол модон эдлэл арвайн гурил үйлдвэрлэл худалдаа эрхлэх зорилгоор байгуулагдсан. Монгол уламжлалт идээ болох арвайн гурилын хэрэглээг хэвээр нь үлдээх, эх орныхоо хөрсөнд ургасан шимтэй чигээр нь хэрэглэгчдэдээ өргөн барихыг хүсдэг. Говь-Алтайн аймгаас шууд татан авалтаар түүхий дээ бэлтгэж, савлаж худалдаалдаг.

ХАЙНАГ ТОЛГОЙ ХОРШОО

☎ 99738672

📍 Хайнаг Толгой Хоршоо

📍 Хайнаг толгой хоршоо, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо толгойт, 97-9 тоот





Үнэт урлагийг таны хэрэглээнд

DEW брэндийг үүсгэн байгуулсан цагаасаа эхлэн манай бүтээгдэхүүн хүрсэн эзэндээ сэтгэл ханамжийн баталгааг 100 хувь өгөх ёстой хэмээн зорьсон. Торгон дээр хээнцэр гоё хээг гараар зурж эхэлсэн энэ брэнд хувцас дизайнер мэргэжлийнхээ дагуу энэ урлагаа хувцсанд шигтгэж, өгсөн. Чөлөөт үндсэн гэх хоёр хэсгээс бүрдүүлэн гараар зурж хээлэн урласан бүтээгдэхүүн нь цор ганц хувь гэдгээрээ онцлог.

Миний урласан хувцас 100 хувийн силкэн дээр дандаа гараар зурдаг учраас нарийн ажиллагаа, их цаг хугацаа шаарддаг. Дахин давтагдашгүй гэдэг утгаараа ч олон тоогоор гардаггүй. Гэхдээ хүссэн хүн ямар ч размераа захиалаад хийлгэх боломжтой.



ДЕЮ ШҮҮДЭР ХХК

88073689 zulaa882006@gmail.com Shuuderbrand dew_shuuder <https://dewbrand.zochil.shop>



AGORA ART

MONGOLIA

МАНАЙ КОМПАНИ АНХ 2021 ОНД БАЙГУУЛАГДСАН, ГЭРИЙН ИНТЕРЬЕРТ
ЗОРИУЛАН ЛАА БОЛОН БУСАД ДЕКОРУУДЫГ УРЛАДАГ.

ТАНЫ ГЭРТ МИНИМАЛ АТЛАА ДУЛААХАН УУР АМЬСГАЛЫГ ЗЭРЭГ
БҮРДҮҮЛЖ ЧАДАХ ИНТЕРЬЕРИЙН ШИНЭ ЧИГ ХАНДЛАГ БҮХИЙ ДЕКОР
БОЛОН ЛААГ ТАНЬД ЗОРИУЛАН УРЛАВ.



АГОРА АРТ МОНГОЛИЯ ХХК 📞 99014816 🌐 Agora Art

БИД МОНГОЛДОО УРЛАВ

Хайртай дотны хүндээ бэлэг болгон өгөхөд төгс бэлэг



📍 Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, River garden хотхон, Их Монгол Плаза, Arteriors дэлгүүр



ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ, ӨВ ТЭЭГЧ, БЭЛГЭДЭЛ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ,
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХАЙРЛАН ДЭМЖИГЧ МАЯРА БРЭНД

МЭДЭР • ТААШАА • БАХАРХ

МАЯРА НЬ ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ ШИНГЭСЭН БАРАА
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭН ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ХЭРЭГЛЭЭНД
НЭВТРҮҮЛЖ, ҮҮГЭЭР ДАМЖУУЛАН ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, СОЁЛЫН ҮНЭ
ЦЭНИЙН ДӨЛИЙГ БАДРААХ ЗОРИЛГОТОЙ.

МАЯРА БРЭНД

☎ 80080919 ✉ info@mayara.mn 🌐 Mayara Mongols 🌐 <https://mayara.mn/>

📍 Улаанбаатар, Монгол улс, Их тойруу худалдааны төв, 3 давхар




MAYARA
МЭДЭР ТААША БАХАРХ





Сайхан сэтгэлээр урлахуй

2018 онд 2 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Бидний урласан цүнхнүүд нь монгол үндэсний дээл хувцас, гоёлын даашинз, өдөр тутмын хувцсан дээр ч донжтой харагддаг давуу талтай.

Манайх нэг цүнхийг ч гараар урлан бүтээгдэг тул захиалгаар тусгайлан гүйцэтгэдэг, мөн олон төрлийн сонголтоор бүтээгдэхүүнүүд бэлэн худалдаалдаг.



ГҮНҮЙЛ ХХК

☎ 88198999 📍 Гүн Үйл/GUNYIL

✉ GUNYIL.BRAND@GMAIL.COM





Гүн-Үйл брэндийн цүнхийг бүх төрлийн торгоор урладаг бөгөөд маш цөөн тооны давтагдахааргүй загваруудыг гараар бүтээдгээрээ онцлогтой юм. Анх энэхүү брэндийг Монгол үндэсний дээлэн дээр тохируулан урласан боловч торгоор урлаан олон үндэстний хувцсан дээр нийцдэг нь хэрэглэгчдийн талархлыг хүлээгээд байна. Тухайлбал Япон кимоно, Энэтхэг сари, Солонгос ханбуг зэрэг олон улсын үндэсний хувцсанд ч тохиромжтой.





Үйсэн брэндийн хавар намрын улавч нь ургамлын идээлэгтэй арьс, царс модны үйсээр хийсэн тул чийг татдаггүй, хөлийг хуурай байлгах таны эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүн. Газар дундын тэнгис болон Хойд Африкийн зөөлөн дулаан уур амьсгалтай газар нутагт ургадаг царс модны холтсыг боловсруулан гаргаж авсан үйс нь чийгийг шингээж авах гайхалтай онцлог шинж чанартай.



СУМАКА ГУТЛЫН САЛОН

☎ 88117276

✉ Info@sumakaandbrothers.com

📍 Sumaka Shoe Salon

📍 Наадам центр 2 давхарт утас: 70101000

📍 Хан-Уулын E mart B1 давхарт утас: 70103000

📍 Саруул худалдааны төв 2 давхарт утас: 70104104





*ӨГЛӨӨНИЙ ЦАЙГАА ЗААВАЛ УУ,
ӨЛӨН ЭЛГЭЭ ЗӨВ ТАЙЛ*

“Гэр бүлийнхээ эрүүл мэндийн төлөө шим тэжээлийн судалгааг хийж, улмаар эрүүл амьдралын дадлыг хэрэгжүүлэхээр хичээж эхэлснээр уламжлалт өв соёл, идээ ундныхаа гайхамшгийг мэдэрч уламжлалт ахуй соёлоо сурталчлан таниулах үйлийг эрхлэхээр Сүүн гэр ХХК-г байгуулсан.

“Сүү цагаа идээний боловсруулах үйлдвэр байгуулна гэсэн зорилгоор өрхийн аж ахуйгаас бизнесээ эхлүүлж байсан. Гэвч бүтээгдэхүүн судалгааны явцад бидний “өглөөний цайны зөв дадал хэвшил” орхигдсон, түүнээс үүдэлтэй маш их өвчний суурь үүсдэгийг олж мэдээд эхнийхээ бүтээгдэхүүнийг “ӨГЛӨӨНИЙ ЦАЙГАА ЗААВАЛ УУ, ӨЛӨН ЭЛГЭЭ ЗӨВ ТАЙЛ” уриатай уламжлалт арвайн бөмбөлгийг үйлдвэрлэхээр шийдсэн. Бид одоогоор 3 төрлийн эслэг бөмбөлгөөрөө дамжуулан “Өглөөний цайны зөв дадал”-д дэм өргөхөөр “ДЭМ” брэндийг зах зээлд танилцуулж байгаа юм.

СҮҮН ГЭР ХХК

☎ 96099292

✉ demmongolia@gmail.com

📍 ДЭМ нэрийн бүтээгдэхүүн

🌐 www.demorganic.com

📍 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Орхоны гудамж





Гар урлалын гайхамшигт зангилаа, нугалаа, хэлхээ ашиглан бүсгүй хүний өдөр тутмын болон гоёлын хэрэгцээг бид сэтгэл зүрхээ зориулан урласаар байх болно.

ҮНДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОХ

- Мандала хослол бга хайрцагтай ээмэг зүүлтны хослол. 12 төрлийн монгол хээтэй
 - Булган оруулагтай энгрийн зүү
- Бүх төрлийн чулуугаар хийгддэг багсармал хослол (зурган дээрх хослол таримал шүрэн)
 - Тухайн сард ямар болохтой холбоотой баярын гоёл, чимэглэл гаргадаг бга.
 - Модон суурьтай лааны суурь, боргоцойтой хаалганы чимэглэл

Индранил малц ХХК

☎ 99174107

✉ Lkhamasurendorjgotov@gmail.com

📘 Lkhamaa's Jewellery

📍 Улаанбаатар, Монгол улс, Баянзүрх дүүрэг, 23-р хороо

Үндсэн бүтээгдэхүүнээ 2 дэлгүүрээр болон үзэсгэлэн худалдаагаар борлуулдаг

Их дэлгүүр | Галарей сувинер их дэлгүүр

Мань бодлоос гарч Миний гараас ургана





ШИНЭ ЭРИНИЙ СОЁЛЫН ГОЛОМТЫГ ХАМТДАА БҮТЭЭЕ

Шинэ эриний соёлын голомтыг хамтдаа бүтээе уриатайгаар 3 жилийн өмнө Бахархал нэрийн дэлгүүрээ Монголчууд болон Монголд хайртай хэн бүхэнд зориулан нээсэн. Өөрийн ур ухаан, авъяас билгээрээ нэгдэн нийлсэн хамт олон үндэсний омог бардам бахархалаа шингээ бүтээл бүрээ шагладаг. Үндэсний хэв маяг, орчин үеийн чиг хандлагатай хослуулан өвөрмөц, дахин давтагдашгүй бүтээгдэхүүн, бүтээл үйлдвэрлэдэг. Мөн цор ганц загварын захиалга дээр ажиллаж Монголын соёлын өвийг түгээн дэлгэрүүлж байна.

СЭЦЭН ФЭЙШН ХХК

☎ 80549900 ✉ baharhal.mglbrand@gmail.com 📘 Setsenfashionllc 📷 setsenfashionllc
🌐 <https://bakharkhal.zochil.shop/>

📍 Улаанбаатар, Баянгол дүүрэг, Төмөр замд Вокзалын хойно. Арктай шар байр





Алсын хараа:

"Эх дэлхийдээ ээлтэй, ухаалаг амьдрах эрмэлзэлтэй бүх насныхан хайрлан хэрэглэдэг дэлхийн брэнд болно."

Эрхэм зорилг:

"Мэдлэг инновац, хайр энэрэл шингээсэн эрүүл мэндэд ээлтэй ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж үнэ цэнийг эрхэмлэгч хэрэглэгч бүрд хүргэнэ."

Үнэт зүйлс:

Мэдлэг, инновац, өв уламжлал, Мэргэшсэн, бүтээлч, нэгдмэл хамт олон,
Хэрэглэгчийг дээдэлсэн чанар, стандарт, Шударга түншлэл, хамтын хөгжил, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Өндөр хариуцлага, ёс зүйтэй үйл ажиллагаа, Байгаль, нийгэмд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл,

Бүүвэй кашемир компани нь ноолууран текстилийн салбарын эрдэмтэд, инженерүүдийн олон жилийн туршид явуулсан монгол ямааны ноолуурын суурь судалгаанд тулгуурлан уг үнэт түүхий эдээр шинэ төрлийн нимгэн нарийн сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор 2018 онд байгуулагдан үйлдвэрлэл туршилт, судалгааны үйл ажиллагаа явуулж ирсэн. Компанийн удирдлага, баг хамт олон өөрсдийн хөгжүүлж буй "Buuvee" брэндээр дамжуулан монголын эрдэмтдийн шинжлэх ухааны мэдлэг шингэсэн оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, экспортыг нэмэгдүүлэх, монгол брэндийг хөгжүүлж, нүүдэлчин монголчуудын ээлтэй (sustainable) арга технологиор өсгөн бойжуулсан малын ашиг шим болох нэн ховор ноолууран түүхий эдийг үнэ цэнтэй бүтээгдэхүүн болгон гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэн, баялаг бүтээхийн төлөө төр засаг, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгчид, малчид, бэлтгэн нийлүүлэгчид, дизайнерууд, маркетинг, менежментийн

БҮҮВЭЙ КАШЕМИР ХХК

☎ 94004324, 77162424 ✉ info@buuveecashmere.com 🌐 BuuveeCashmere 🌐 buuveecashmere.mn | www.buveecashmere.com

📍 Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 11-р хороо, Эмералд ливинг хотхон 48/8 тоот

Үнэ цэнийг хамтран бүтээж үр шимээ хамтдаа хүртье!

мэргэжилтэн, зөвлөхүүд зэрэг оролцогч талууд инновацын түншлэлийн хүрээнд үр өгөөжтэй хамтран ажиллах кластерын системийг эх орондоо бүтээлчээр хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. “БҮҮВЭЭ” брэндийн 100% ноолууран нарийн сүлжмэл бүтээгдэхүүн нь эрдэмтэдийн 20 гаран жилийн судалгааны үр дүнгээр гарган авсан патентлагдсан утсаар хийгдэж ноолууран бүтээгдэхүүнийг зөвхөн хүйтэн сэрүүний улиралд тохиромжтой гэсэн хэрэглэгчдийн уламжлалт хандлагыг өөрчлөх, жилийн 4 улиралд хэрэглэхэд зохимжтой, шууд биен дээрээ өмсөж болох арьсны дархлааг дэмждэг инновацын цоо шинэ бүтээгдэхүүн юм. “Buuvee” брэндийн бүтээгдэхүүнүүд Монгол, Америк, Герман, Ирланд, Солонгос, Хятадын зах зээлд тодорхой тооны хэрэглэгчдэд хүрч, зуны +30, өвлийн -30 хэмд ч өмсөж байгаа хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн өндөр үнэлгээ аваад байна.





Энхрий брэнд бяцхан үрсдээ зориулан ус сайн авдаг, харшил өгөхгүй, бөөсөрч, ноорохгүй хамгийн гоё зөөлөн материалтай хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн



ЭНХРИЙ БРЭНД ХХК

80002105

enhrii brand

enhrii_brand

<https://enhrii.mn>

ЭНХРИЙ
БРЭНД






“Улаанбаатарт байдаг “Урлаглаг бяцхан диваажин” -г та мэдэх үү?

ЦЭЦЭГ, КЕРАМИК, БЭЛЭГ ДУРСГАЛЫН ДЭЛГҮҮР

ХОТЫН ХАМГИЙН ЖИЖИГ КОФЕ ШОП

УРАН БҮТЭЭЛЧДИЙН БҮТЭЭЛИЙГ АВАХ БОЛОМЖТОЙ БЯЦХАН ГАЛЕРЕЙ

зэрэг хөөрхөн бүхнийг багтаасан их хотын зүрхэн дэх диваажингийн хэлтэрхий **“Little Heaven”**.



Little heaven дэлгүүр нь цэцэг, керамик, мэргэжлийн уран бүтээлчдийн бүтээл уран зураг, керамик урлал, гар урлал, бэлэг дурсгалын зүйлс болон монголдоо гар аргаар үйлдвэрлэсэн органик саван, арьс арчилгаа, дотоодын үйлдвэрлэгчдийн хувцас бүтээгдэхүүнийг санал болгодог концепц дэлгүүр юм.

ЛИТЛЭ ХЭВИН ХХК

☎ 80009908

✉ littleheaveninub@gmail.com

📘 [littleheavenub](https://www.facebook.com/littleheavenub)



📷 [little_heaven_in_ub](https://www.instagram.com/little_heaven_in_ub)

📍 Peace Avenue Road, block 12, Khoroo 1, Chingeltei 15170 Ulaanbaatar, Mongolia

“Кофе шоп маань бүх төрлийн кофе, шинэхэн жимс ногооны смүүти, веган болон энгийн амттан, веган латте зэрэг эрүүл тэнцвэртэй амьдралын хэв маягийг эрхэмлэгч хэн бүхний хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнүүдээр үйлчилдэг. Жилийн дөрвөн улиралд манай гадаах бяцхан цэцэрлэг хэчнээн үзэсгэлэнтэй гээч.



“Эрүүл, Эерэг, Урлаглаг” бүхнийг түгээдэг бяцхан диваажинд өглөөний кофе цай, үдшийн романтик болзоо, мөн түүнчлэн сургалт, уулзалт, зураг авалт гэх мэт бүх төрлийн ивэнт зохион явуулах боломжтой.



Та Little Heaven -д нэгэн таатай өдрийг өнгөрөөж чадахаас гадна, бүх л хайртай дотны хүмүүс, найз нөхөд, гадны жуулчид гээд хэн бүхнийг дагуулан ирэхийг хүсэх газар мөн гэдгийг бид итгэлтэй хэлж байна.



Мөн бид хүргэлтийн үйлчилгээтэй бөгөөд та хайртай хүмүүстээ барих хамгийн үзэсгэлэнтэй баглаа цэцэг, хүссэн бүхнээ сонгон авах бэлгийн карт, кофетой болзооны урилга зэргээ хүргүүлэн аваарай.



“Хүүгийн Гутал” ХХК нь анх 1994 онд гутлын үйлдвэрлэл болон худалдааны чиглэлээр байгуулагдаж, өдгөө 28 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Манай байгууллага мэргэжлийн загвар зохион бүтээгч, технологич болон мэргэжлийн зэрэгтэй тавь гаруй ажилтан ажилчидтай, өдөр тутмын болон гоёлын төрөл бүрийн загварын гутлыг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг үндэсний үйлдвэрлэгчдийн нэг юм.



ХҮҮГИЙН ГУТАЛ ХХК

☎ 99854073 | 88111157 | 77312222

✉ khuugiingutal1@gmail.com [f](#) [khuugiinguta](#) [@](#) [khuugiingutal](#)

📍 БЗД, Баянзүрх захын баруун талд 136 байр.



Бүтээгдэхүүнийхээ түүхий эдийг бид Орос, БНХАУ, Солонгос болон дотоодын арьс боловсруулах үйлдвэрүүдээс нийлүүлдэг бөгөөд орчин үеийн техник технологид суурилсан конвейерийн шугам системээр ээлжиндээ 250-300 хос гутал үйлдвэрлэдэг





“Түмэн Түгээлт ХХК” нь 2016 оны 4 сард анх үүсгэн байгуулагдсан. Анх ахуйн барааны борлуулалт түгээлтийн чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлсэн . 2018 оны 3 сараас үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эхэлсэн. ХОБ ХОБ брэндийг үүсгэн одоог хүртэл тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна .

100 гр болон 450 граммын савлагаатай 6 төрлийн амт, өнгө төрх бүхий 9 бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэн ажиллаж байна. Одоогоор Монголын томоохон 30 сүлжээ болон супермаркетуудтай хамтран ажилладаг.

Бүтээгдэхүүний онцлог: Уламжлал шинэчлэлийг хослуулсан их хотын амьдралд нийцсэн өнгө төрх амтыг шингээсэн , ямар нэг хадгалах хугацаа уртасгах бодисгүй цэвэр аарц болон үзэм, жимс , самар, шоколад , гааны хосолмол импортын чихрийг оролхуйц үрлэн ааруулан чихэр юм.



☎ 86558355 , 88028686 ✉ tmentgeelth@gmail.com 📘 [tumentugeelt](https://www.facebook.com/tumentugeelt)

📍 Улаанбаатар , Баянзүрх Дүүрэг , 30-р хороо, Цэргийн хотхон 258В



Эрүүл төгс амттай
Түмэнд Түгээгч



*Миний бие Тэмбосүрэн Оюунбилэг нь
нохор 7 хүүхдийн хамт амьдардаг, 40
настай.*

*2012 оноос хойш хувиараа оёдол
өдгий хуртэл хийж байгаа, зүү ороох
оёдол болон дээл оёдог. 1-2 дэлгүүрт
нийлүүлэн борлуулдаг бас хувь хүн болон
албан газраас захиалга авж оёдог.*

НАНДИН УРЛАЛ БРЭНД

☎ 88718686

🌐 <https://www.facebook.com/profile.php?id=100058729720479>

📍 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 14-р хороо, Хайлааст 11-196 тоот



Зүү ороох оёдоллоор
дахин давтагдашгүй
бүтээл урладаг





Бүтээл бүхнээ зөвхөн танд зориулав

Дахин давтагдашгүй Монгол арьс ширэн гар урлалын бүтээлүүд/бүтээгдэхүүн/ уралдаг. Энэ бизнесийг эрхлэх болсон шалтгаан гэвэл, “Нүүдэлчин сэрэхүй” брэнд бий болгох төсөл нь Монгол үндэстний өв соёл, аж амьдралын хэв маягийг тусгасан өөрийн гэсэн өнгө төрх, үзэмжтэй бүтээгдэхүүнийг монголынхоо хэрэглэгчдэд хүргэх юм. Энэ бүс нутагт хөл дээрээ тогтон өсөж яваа манайхтай адил/ижил/ бизнес эрхлэгч цөөн тул энэ төрлийн бизнес эрхлэгч тал дээр манайх монопол байх болно. Манай бүтээлүүд Монгол үндэстний өв соёл, аж амьдралын хэв маягийг агуулсан, Маш чанартай монгол үхрийн шир болон хонь ямааны арьсаар уралдаг учир хэрэглэгчид маань сонгон, худалдан авахдаа дуртай байдаг. Мөн бүх насны хэрэглэгчид үйлчлүүлдэг.

НҮҮДЭЛЧИН СЭРЭХҮЙ БРЭНД

☎ 99395513

📍 DELGEGUUR

📍 Налайх дүүрэг, 5-р хороо, Гандан Туул 5-6 тоот





ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ

УЛААНБААТАР ХОТ (төв салбар)

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяан гүний гудамж, 18/1, The Downtown оффис, 5 давхар, 501 тоот
☎ 7722-2210

ОРХОН САЛБАР

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Амгалан Оршихуй Ордон, 1 давхар, 103 тоот
☎ 7766-2210

ХОВД САЛБАР

Ховд аймаг, Жаргалант сум, Магсаржав баг, Ш.Ренчингийн 2-р гудамж, 201-р байр, "Ханжаргалант Ховд" хоршооны 1 давхар, 2 тоот
☎ 7700-2210

ДОРНОД САЛБАР

Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг, 62-р байрны үйлчилгээний төв, 2 давхар, 5 тоот
☎ 7058-2210

ДОРНОГОВЬ САЛБАР

Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, Цахим үйлчилгээний төв, 3 давхар
☎ 7557-2210

ЗАВХАН САЛБАР

Завхан аймаг, Улиастай сум, Жинст баг, Төрийн банк, 1 давхар
☎ 7046-2210

БАЯНХОНГОР САЛБАР

Баянхонгор аймаг, Номгон сум, 1-р баг, Эрхэт Цамхаг, 4 давхар, 408 тоот
☎ 7708-2210

СЭЛЭНГЭ САЛБАР

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 6-р баг, 1-р хэсэг, Сэлэнгэ Титан ХХК-ийн байр, 2 давхар
☎ 7600-2210

ДАРХАН-УУЛ САЛБАР

Дархан-Уул аймаг, Дархан сум, 12-р баг, Дархан ТЕДИ төв, 2 давхар, 202 тоот
☎ 7577-6060

ХӨВСГӨЛ САЛБАР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг, Баянцагаан худалдаа үйлчилгээний төв, 2 давхарт, 8203 тоот
☎ 8500-3338, 8500-3337

ӨВӨРХАНГАЙ САЛБАР

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Ренчинпэлжээгийн гудамж, Норжүн төв 1-р давхар
☎ 8500-6333, 8500-7333

ӨМНӨГОВЬ САЛБАР

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Хан-Уул зочид буудлын өргөтгөл, 3 давхар 301 тоот
☎ 8500-5333, 8500-4333

ХЭНТИЙ САЛБАР

Хэнтий аймаг Хэрлэн сум 1-р баг Монгол эм импекстэй байр 2-р давхар
☎ 8500-8333, 8500-9333



BESTprogramMN



BESTprogram1



dsmongolia.org



info@dsmongolia.org